



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ
АХЛАХ СУРГУУЛЬ
ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

Г “Суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх түр журам”-д нэмэлт оруулах тухай Г

“МУИС-ийн Байгаль-Эх лицей ахлах сургууль, Экологийн боловсролын төвийн дүрэм”-ийн 4.7 дахь заалт, Захирлын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх түр журам”-д дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй. Үүнд:

5 дахь заалт:

“5. Олон улсын уралдаан, тэмцээнд оролцож алтан медаль хүртсэн бол 50 %, мөнгөн медаль хүртсэн бол 30 %, хүрэл медаль хүртсэн бол 20 %-ийн төлбөрийн хөнгөлөлт тус бүр үзүүлнэ”.

2. Энэ тушаалыг 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



П.ТҮВШИНТӨР

201900190

Захирлын 2019 оны 10... дугаар
сарын 01...-ны өдрийн 1/17 дугаар
тушаалаар батлав.

УХА0689 8919711

СУРАЛЦАГЧДАД СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ

Зорилго: Суралцагчдын олимпиадын амжилтыг урамшуулах, гаргасан амжилтаа цаашид ахиулах сэдэл төрүүлэх, бусдад сайн үлгэр жишээ болгох, суралцагч нэг бүрийн сурлагын чанарын ахиц амжилт нэмэгдэх.

Үндэслэл:

- МУИС-ийн Байгаль-Эх лицей ахлах сургууль, Экологийн боловсролын төвийн дүрэм"-ийн 4.7 дахь заал
- Захирлын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэр

1. Төрөлжсөн олимпиадад амжилт үзүүлсэн суралцагчдад дараах байдлаар сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлье.
 - Улсад алт, мөнгө, хүрэл медаль 100%
 - Нийслэлд алт 50 %, мөнгө 40% хүрэл 30%
 - Дүүрэгт алт 20%, мөнгө 15, хүрэл 10%.
2. МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей ахлах сургуулийн нэрэмжит “Газрын зургийг хэн сайн мэдэх вэ?” тэмцээнд дараах амжилтыг үзүүлсэн суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлье. /Энэ хичээлийн жилийн хувьд/.
 - Алт 30%
 - Мөнгө 20%
 - Хүрэл 10%
3. Бусад: нэрэмжит олимпиад уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн бол сургалтын төлбөрийн зохих хувийн хөнгөлөлт үзүүлнэ. /2018-2019 оны хичээлийн жилд/
 - Алт 5%,
 - Мөнгө 3%,
 - Хүрэл 2%
4. Байгалийн ухааны хичээлүүдийн багийн олимпиадад үзүүлсэн амжилтыг харгалзан сургалтын төлбөрийн дараах хувийн хөнгөлөлт үзүүлнэ.
 - Алт 40% /баг хамт олонд/
 - Мөнгө 30% /баг хамт олонд/
 - Хүрэл 20% /баг хамт олонд/
5. Олон улсын уралдаан, тэмцээнд оролцож алтан медаль хүртсэн бол 50 %, мөнгөн медаль хүртсэн бол 30 %, хүрэл медаль хүртсэн бол 20 %-ийн төлбөрийн хөнгөлөлт тус бүр үзүүлнэ”.